



**МОНГОЛ УЛС**  
**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМНЫ  
ДЭРГЭДЭХ САЛБАР  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
Д.ГАНБОЛД ТАНАА

2020.04.30 № 03/825  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийг шинэчлэн байгуулсан тухай Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 152 дугаар тогтоолыг хүргүүлж байна.

Хавсралт .. хуудас.

ГИШҮҮН



С.ЦЭДЭНДАМБА



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 152

Улаанбаатар хот

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн  
бүрэлдэхүүнийг шинэчлэн томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3, 65.6 дахь хэсэг, "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн 5.7 дахь заалт, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 2.1, 2.4, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх салбар зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Салбар зөвлөлийн дарга: Д.Ганболд-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд: Т.Булган-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга  
П.Цогтсайхан-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын дарга  
Б.Оюунсанаа-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Ойн бодлого, зохицуулалтын газрын дарга  
В.Жавзан-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга  
Х.Батжаргал-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Уур амьсгалын өөрчлөлт, гадаад хамтын ажиллагааны газрын дарга

Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга: Г.Бадамдулам-Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

2.Төрийн албаны тухай хууль тогтоомж, "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн дарга /Д.Ганболд /-д даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албаны салбар зөвлөл байгуулах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 169 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

2020.03.22